# БСБ - Төв Азийн Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих хөтөлбөр – Вишнфанд ББСБ

Улс:
Монгол

Төслийн дугаар:
52677

Бизнесийн салбар:
Банк санхүү (банк бус)

Мэдээллийн төрөл:
Хувийн хэвшил

Байгаль орчны ангилал:
СЗБ

Удирдах зөвлөл хэлэлцэх огноо:
2021 оны 11 дугаар сарын 23

Төлөв байдал:
Батлагдсан

Төслийн Хураангуй баримт бичиг /ТХББ/ Англи хэлээр танилцуулсан огноо:

## Төслийн танилцуулга

ЕСБХБ-ны Санхүүжилтийг үндэсний мөнгөн тэмдэгтээр олгох хөтөлбөрийн хүрээнд 460,000 ам.доллар хүртэлх (төгрөгөөр) анхдагч өглөгт тооцогдох зээлийг олгох. Тус зээлийг Вишнфанд ББСБ ХХК-д хоёр хэсэг болгон олгож Төв Азийн Бизнес эрхлэгч Эмэгтэйчүүдийг дэмжих Хөтөлбөрийн (ТА БЭЭДХ) хүрээнд бичил, жижиг дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд дамжуулан зээлдүүлэхэд зориулагдана.

## Төслийн зорилго

Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлтийг дэмжин нийслэл, хөдөө орон нутгийн хувийн хэвшлийн салбар дахь эмэгтэйчүүдийн оролцоог дэмжин бичил, жижиг ба дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн санхүүгийн хүртээмж нэмж, ноу хау болон зөвлөгөө өгч дэмжлэг үзүүлэхэд төслийн зорилго оршино.

Бичил, жижиг ба дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн хувьд тулгарч буй хамгийн том саад бэрхшээл нь санхүүжилтийн дутагдал байна.

## Шилжилтийн нөлөөлөл

Шилжилтийн нөлөөллийн үнэлгээ: 70

Энэхүү төсөл нь Төв Ази дахь Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих Хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэн, Тэгш оролцоо ба Өрсөлдөх чадварууд бүхий чанаруудыг бий болгосноор шилжилтийн нөлөөлөл үзүүлэх хүлээлттэй байна. Тус зээл нь эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлтийг дэмжихийн зэрэгцээ "санхүүгийн хүртээмж" ба "ажил эрхлэлт, бизнес эрхлэлт"-ийн жендерийн дутагдлуудыг багасгаж бизнесийн орчинд эмэгтэйчүүдийн идэвхтэй оролцоог дэмжинэ. Энэ зээл нь Монгол Улсад хэрэгжүүлж буй Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд олгогдох анхны хоёр зээлийн нэг нь юм.

## Харилцагчийн мэдээлэл

Вишнфанд ББСБ ХХК

Вишнфанд ББСБ нь 2004 онд Зөн Сан Монгол ББСБ нэртэйгээр Дэлхийн Зөн Олон улсын Байгууллагын хөтөлбөрийн Монголд хэрэгжүүлэх зорилготой үүсгэн байгуулагдсан. 2007 онд тус ББСБ нь Монголын амьжиргаа доогуур өрх, гэр бүл, бизнес эрхлэгч айл өрхүүдэд эдийн засгийн боломжуудыг нээх, ажлын байр, орлоготой болгох эрхэм зорилго бүхий ББСБ болгон нэрээ өөрчилсөн. Вишнфанд ББСБ нь Вишнфанд ОУБ-ын охин компани бөгөөд Монголын тэргүүлэх 10 бичил санхүүгийн байгууллагуудын нэг юм. Тэд Монгол улсад төв оффис, 9 салбар, 3 төлөөлөгчийн газраараа дамжуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

## ЕСБХБ-ны санхүүжилтийн тойм

460,000.00 ам.доллар (400,000 евротой тэнцэх дүн)

## Төслийн нийт өртөг

460,000,00 ам.доллар

ЕСБХБ-ны санхүүжилт: 400,000 евротой тэнцэх дүн

## Байгаль орчин, нийгмийн тойм

Санхүүгийн зуучлагчид - ангилал (2019 оны Байгаль орчин, нийгмийн бодлого баримт бичиг). Вишнфанд ББСБ ХХК нь өмнө ЕСБХБ-тай хэрэгжүүлсэн төслийн хүрээнд Байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй байдлын стандартууд болон

тэдгээрийн хэрэгжилтийн талаар мэдээлэл өгсөн. ЕСБХБ-ны Байгаль орчин, аюулгүй байдлын газраас харилцагч байгууллагын удирдлагуудтай уулзаж төслийн хэрэгжилтийн талаар ярилцсан. Вишнфанд ББСБ үнэлгээ хийх арга барил болон шалгуурууд нь тухай байгууллагын харилцагчдад тохирсон эрсдэлийн үнэлгээ хийж буйг харуулсан. Өмнө олгосон зээл нь 2014 оны Байгаль орчин, нийгмийн бодлого баримт бичгээр зохицуулагдаж байсан бол тус зээл нь 2019 оны Байгаль орчин, нийгмийн бодлого баримт бичгээр зохицуулагдана. Харилцагч байгууллага Гүйцэтгэлийн шаардлага 2 ба 4-т нийцсэн дотоод үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, зээлдүүлэх үйл ажиллагаанд ЕСБХБ-ны Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандартуудыг мөрдүүлнэ.

# Техник хамтын ажиллагаа

**А. Техник хамтын ажиллагаа /ТХА/**

Төв Азийн Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих Хөтөлбөр (ТА БЭЭДХ)-ийн хүрээнд олгогдох ТХА нь дараах хоёр хоорондоо хамааралтай хэсгээс бүрдэнэ:

(i) Харилцагч санхүүгийн зуучлагч байгууллагуудад зориулсан чадавх сайжруулах хөтөлбөр

Санхүүжилтийн эх үүсвэр: We-Fi

Дүн/валютын төрөл: Төв Азийн Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн Хөтөлбөрийн төвшинд 5 сая ам.доллар

Санхүүжилтийн төлөв: Батлагдсан

(ii) Зөвлөх Үйлчилгээ Хөтөлбөрөөр дамжуулан эмэгтэйчүүдийн эзэмшлийн ЖДҮ-ийн чадавх сайжруулах хөтөлбөр

Санхүүжилтийн эх үүсвэр: We-Fi

Дүн/ валютын төрөл: Төв Азийн Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн Хөтөлбөрийн төвшинд 4.5 сая ам.доллар

Санхүүжилтийн төлөв: Батлагдсан

**Б. Хамтарсан буцалтгүй тусламж/ Концессийн Санхүүжилт (Техник хамтын ажиллагаа бус)**

БЭЭДХ-ийн хүрээнд зээлийн 10 хүртэлх хувийг Эхний Эрсдэлийн даатгалаар хамгаалсан буюу 46,000 ам.долларын (зээл тус бүрийн 70% хүртэлх) алдагдлыг нөхөх эрсдэлийн хамгаалалт багтаасан. Энэ Хөтөлбөрт оролцсоноор Вишнфанд ББСБ ХХК-ийн зээлийн алдагдлыг дээрх байдлаар нөхөх юм.

Санхүүжилтийн эх үүсвэр: We-Fi

Дүн/валютын төрөл: 46,000 ам.доллар

Санхүүжилтийн төлөв: Батлагдсан

Техник хамтын ажиллагаа бус: Эхний Эрсдэлийн даатгал нь ЕСБХБ-ны эхний эрсдэлийг ЖДҮ Үндэсний мөнгөн тэмдэгтийн тусгай сангаас санхүүжүүлэн даана.

## Нэмэлт ашиг тус

**Санхүүжилтийн бүтэц:** ЕСБХБ зах зээл дээр байхгүй байгаа үндэсний мөнгөн тэмдэгтээрх санхүүжилтийн нөхцөлүүдийг санал болгож байна.

**Мэдлэг, инноваци, ба чадавх сайжруулах:** ЕСБХБ-аас харилцагч байгууллагад хэрэгцээтэй чадавх бэхжүүлэх, төслийн зорилгуудыг цаг тухайд нь биелүүлэхэд шаардлагатай техникийн туслалцаа үзүүлнэ.

## Холбоо барих хүний мэдээлэл

Гүйцэтгэх захирал Хатагтай Нурхаярах Садава
Arah_sadava@wvi.org
+97670129772
www.visionfundmongolia.org
403, Соманг Плаза, 13-р хороолол, 15-р хороо, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс

## Шилжилтийг ойлгох нь

Шилжилтийн нөлөөллийг хэмжих чиглэлд ЕСБХБ-ны баримталдаг арга хандлагын талаарх нэмэлт мэдээллийг эндээс авна уу.

## Бизнес боломжууд

Бизнес боломжууд болон худалдан авалтын талаар үйлчлүүлэгч компанитай холбогдоно уу.

ЕСБХБ-тай хамтран ажиллах боломжууд (худалдан авалттай холбоогүй)-ын талаар сонирхвол дараах утасны дугаар, цахим хаягаар холбоо барина уу.

Утас: +44 20 7338 7168
Цахим шуудан: projectenquiries@ebrd.com

Төрийн хэвшлийн төслүүдтэй холбоотой мэдээлэл авахыг хүсвэл ЕСБХБ-ны Худалдан авалт хэсэгт зочилно уу.

Утас: +44 20 7338 6794
Цахим шуудан: procurement@ebrd.com

## Ерөнхий лавлагаа

Дэлгэрэнгүй лавлагааг ЕСБХБ-ны Лавлагааны маягт ашиглан авах боломжтой.

# Байгаль орчин, нийгмийн бодлого (БОНБ)

БОНБ болон холбогдох Гүйцэтгэлийн Шаардлагууд (ГШ) нь ЕСБХБ-ны “байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжил”-ийг хөхиүлэн дэмжих үүрэг амлалтаа биелүүлэхэд баримтлах арга замуудыг тодорхойлдог. БОНБ болон ГШ-д үйлчлүүлэгчийн зүгээс олон нийтийн мэдээлэл, хэлэлцүүлгийн талаарх үндэсний хууль тогтоомжийн холбогдох заалтуудыг дагаж мөрдөх , мөн оролцогч талуудын санал гомдол, ялангуяа үйлчлүүлэгч ба төслийн байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн талаарх санал гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг гомдол барагдуулах механизм бий болгох тухай тодорхой заалтууд багтсан байдаг. ЕСБХБ нь аливаа төслийн байгаль орчны болон нийгмийн эрсдэл, нөлөөллийн мөн чанар, цар хүрээнд дүйцүүлэн, тухайн төслийн улмаас үүсэх эрсдэл, үр нөлөөллийн тухай мэдээллийг шаардлагын дагуу ил болгох, эсвэл оролцогч талуудтай утга учиртай зөвлөлдөх, тэдний санал хүсэлтийг харгалзан үзэж, хариу өгөх нэмэлт шаардлагыг үйлчлүүлэгчиддээ тавьдаг.

Энэ чиглэлд ЕСБХБ-ны хэрэгжүүлдэг практикийн талаарх нэмэлт мэдээллийг БОНБ-д оруулсан болно.

# Бүрэн төгс байдал ба комплаенс

ЕСБХБ-ны Комплаенс хариуцсан Захирлын Ажлын алба (КЗАА) нь сайн засаглалыг хөхиүлэн дэмжиж, олон улсын шилдэг практикт нийцүүлэн Банкны бүхий л үйл ажиллагаан дахь бүрэн төгс байдлыг хамгийн дээд стандартаар хангахад анхаарч ажилладаг. Төслүүдийн зүгээс Банкинд бүрэн төгс байдал, нэр хүндийн хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй эрсдэл үүсгэхгүй байх нөхцлийг хангахын тулд тус Банк бүх үйлчлүүлэгчийнхээ бүрэн төгс байдалд нарийвчилсан үнэлгээ хийдэг. Банк аливаа асуудлыг төслийн үнэлгээг батлах үе шатанд илрүүлэн тогтоож, шийдвэрлэх нь Банкны транзакцийн бүрэн төгс байдлыг хангах хамгийн үр дүнтэй арга зам гэж үзэж байна. КЗАА нь эдгээр хамгаалалтын арга хэмжээг авахад голлох үүрэг гүйцэтгэж, мөн төслүүдийн хөрөнгө оруулалтын дараах бүрэн төгс байдлын эрсдлийг хянахад тус дөхөм үзүүлдэг.

Түүнчлэн, КЗАА нь ЕСБХБ-ны санхүүжүүлсэн төслүүдтэй холбоотой залилан мэхлэлт, авилга, хээл хахууль болон буруу үйлдлийн талаарх гомдлын мөрөөр судлан шалгах үүрэгтэй. Банкны ажилтнууд, эсвэл гадна байгаа хэн ч бай залилан мэхлэлт болон авилгал үйлдэгдсэн хэмээн сэжиглэж буй тохиолдолд Комплаенс хариуцсан захиралд compliance@ebrd.com цахим шуудангийн хаяг руу бичгээр илтгэх ёстой. Мэдээлэгдсэн бүхий л асуудлын мөрөөр хянан шийдвэрлэх ажлыг КЗАА гүйцэтгэнэ. Нэр хаягтай болон нэр хаяггүй бүх мэдээллийг шалгана. Мэдээллийг Банкны албан ёсны хэл болон үйл ажиллагаа явуулдаг улс орнуудын хэлний алинаар ч үйлдэж болно. Ирүүлсэн мэдээлэл нь чин сэтгэлийн байх ёстой.

# Мэдээллийн хүртээмжийн бодлого (МХБ)

МХБ нь 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш ЕСБХБ мэдээллийг хэрхэн олон нийтэд ил тод болгох, өөрийн стратеги, бодлого болон үйл ажиллагааны талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэн сурталчлах чиглэлд оролцогч талуудтай хэрхэн зөвлөлдөх арга замуудыг тодорхойлсон байдаг. ЕСБХБ-ны вэб сайтаас ямар мэдээлэл авах боломжтойг мэдье гэвэл Мэдээллийн хүртээмжийн бодлого хуудсанд зочилно уу.

Мэдээлэл авах тодорхой хүсэлтээ ЕСБХБ-ны Лавлагааны маягт ашиглан илгээх боломжтой.

# Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)

Хэрэв байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбоотой санал гомдлоо үйлчлүүлэгч болон Банкинд тавьж шийдвэрлүүлэх (жишээлбэл: үйлчлүүлэгчийн Төслийн түвшний гомдол барагдуулах механизмаар дамжуулж, эсвэл Банкны удирдлагатай шууд харилцах замаар) оролдлого, хүчин чармайлт нь амжилтгүй болвол, хувь хүн болон байгууллагууд санал гомдлоо ЕСБХБ-ны Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)-аар дамжуулан шийдвэрлүүлэхийг зорьж болно.

ТХХБМ нь Төсөлтэй холбоотой бусдад хор хохирол учруулсан (эсвэл учруулж болзошгүй) гэж үзэж буй асуудлуудыг хараат бусаар хянан шалгадаг. Энэхүү Механизмын зорилго нь байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбогдох асуудлуудыг шийдвэрлэх талаар Төслийн оролцогч талуудын хоорондох яриа хэлэлцээг дэмжих; Банк өөрийн Байгаль орчин, нийгмийн бодлого, эсвэл Мэдээллийн хүртээмжийн бодлого–ын Төсөлд холбогдох заалтуудыг дагаж мөрдсөн эсэхийг тогтоох; мөн шаардлагатай тохиолдолд Банкны зүгээс эдгээр бодлогод үл нийцсэн зөрчлийг арилгах, түүний зэрэгцээ цаашид тийм зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

ТХХБМ болон түүний эрх үүргийн талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл Төслийн хариуцлагын хараат бус механизмын вэб сайт, хянан шалгуулах хүсэлт тавих бол Хүсэлт хаягаар тус тус хандана уу. Эсвэл ТХХБМ-ын талаар, мөн санал хүсэлт хэрхэн тавих тухай чиглэл заавар, нэмэлт мэдээлэл авах бол ipam@ebrd.com цахим шуудангаар хандаж болно.